



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар A/78

Мандалговь

Г Салбар зөвлөл байгуулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "е", 29.1.6 "а" заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Зам тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 48 дугаар тушаалаар батлагдсан "Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Дундговь аймаг дахь "Аэродром орчимд агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Б.Батмөнх ("Мандалговь" нисэх буудлын дарга)
Гишүүд:	Д.Нэргүй (Аймгийн ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга) С.Цэрэнчунт ("Мандалговь" нисэх буудлын нислэгийн мэдээллийн ажилтан) О.Мөнхзүл (Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Барилга хот байгуулалт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн) Д.Мөнхцоож (Сайнцагаан сумын Хот тохижуулах газрын дарга) Ж.Миесүрэн (Сайнцагаан сумын Байгаль, орчны Улсын байцаагч)
Нарийн бичгийн дарга:	Ж.Мөнхтөр ("Мандалговь" нисэх буудлын Аэродромын техникич)

Хоёр. "Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж хариуцлага, санаачилгатай ажиллахыг "Аэродром орчимд агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх салбар зөвлөл"-д даалгасугай.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн ажлын зохион байгуулалтанд хуулийн хүрээнд хяналт тавьж ажиллахыг салбар зөвлөлийн дарга (Б.Батмөнх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



488190206